

МОНГОЛ УЛС ДАХЬ ХЯТАДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ

*Н.Ариунгуа**

*Ч.Батцэцэг***

Монгол Улсын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн олон талын тууштай бодлогын үр дүнд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, нийгэм эдийн засгийн үр нөлөө мэдэгдэхүйц дээшилсээр байна. Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын үндсэн зорилго нь гадаадын хөрөнгө оруулагчдад татварын болон бусад хөнгөлөлт, урамшуулал олгох, тэдгээрийн хөрөнгө өмчлөх эрх, хөрөнгө оруулалтыг хамгаалах хууль зүйн баталгааг хэрэгжүүлэх, хүнд суртлыг арилгахад оршдог.

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжснээр гадаадын хөрөнгө оруулалтанд онцгой анхаарал хандуулж эдийн засгийн тасралтгүй хөгжлийн чухал хүчин зүйл, эх сурвалж нь хэмээн үзсээр ирсэн билээ. Энэхүү үзэл баримтлал нь Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль (МУЗГ 2002), Монгол Улсын нэгдэн орсон олон улсын болон хоёр талын гэрээ, хэлэлцээгээр баталгаажин хамгаалагдсан болно. Нөгөөтэйгүүр манай засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хууль зүйн орчныг бий болгож 1993 оноос Монгол Улсын “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. 2005 оноос манай улсын засгийн газраас “Хөрөнгө оруулагчдын чуулга” уулзалтыг эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол бүхий хүнд үйлдвэр, уул уурхай, хөнгөн үйлдвэр, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй, дэд бүтэц (барилга, мэдээлэл, харилцаа холбоо, эрчим хүч) салбарын хүрээнд дэс дараалалтай зохион байгуулж, Гадаадын Хөрөнгө Оруулагчдыг (ГХО) дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн интеграцид оролцох шинэ боломжийг нээж өгснөөрөө нэн ач холбогдолтой хэмээн үзэж байгаа юм. Энэ бол үндэсний хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд чухал том хөшүүрэг болох бөгөөд Монголын гадаад түншүүдийн Техникийн уулзалтын үеэр гаргасан тооцоогоор 2015 он хүртэлх хугацаанд 10 тэрбум ам.долларын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шингээх чадвар бий гэсэн дүгнэлт гаргасан байна.¹ Сүүлийн үед манай ерөнхий сайд асан С.Баярын Европын Холбооны орнуудад хийсэн айлчлалын үеэр гадаадын олон компани ихээхэн хэмжээний хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлсэн байдлыг тооцвол их хөрөнгө

* Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) дэд профессор

** Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) дэд профессор

татах, томоохон төслүүд хэрэгжүүлэх боломж байгааг харуулж байна. Иймээс манай улс хөрөнгө оруулалтын орчноо улам төгөлдөржүүлэх, хөрөнгө оруулалтын орчинд таагүй нөлөөлж буй хүчин зүйлийг цаг тухайд нь тодорхойлон түүнийг цаашид засварлах, сайжруулах арга хэмжээ авах, дунд болон урт хугацаанд аль салбар, ямар чиглэлээр гадаад хөрөнгө оруулалтыг түлхүү хийхийг Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусган тодорхойлох зэрэг юм. Нөгөөтэйгүүр хөрөнгө оруулалтыг сайжруулах хүрээнд зөвхөн хууль эрх зүй, татварын бодлогоос гадна олон улсын жишгийн дагуу бусад тодорхойлогч үзүүлэлтийг засч залруулах гэх мэт.

Манай улсад үндэстнийхээ хөгжил цэцэглэлтийг тодорхойлох төдийгүй бүс нутгийн хэрэгцээг хангахуйц дэлхийн хэмжээний Оюу толгойн зэс алтны орд, Тавантолгойн нүүрсний орд, Бүрэнхааны фосфорит, Дархан, Сэлэнгийн төмрийн орд, Улаан толгой, Улаан хадны нүүрсний орд, Төмөртэйн цайрын орд, Асгатын ураны орд, Хөшөөтийн орд зэрэг 60 гаруй бүлэг том орд, мөн төрөл бүрийн ашигт малтмалын олон арван ордын нөөц тогтоогдож, аж ахуйн эргэлт, ашиглалтанд орох нөхцөл бүрдээд байгаа билээ. Эдгээр орд илэрснээр Монгол Улс дэлхийн улс орон түүн дотор ОХУ, БНХАУ, АНУ, Канад, Япон, Солонгос болон бусад олон орны хөрөнгө оруулагчдыг ихээр татаж, эхнээсээ хамтран олборлох гэрээнд гарын үсэг зураад байна. Монгол Улс Оюу толгойн төсөл хэрэгжүүлж эхэлснээр шинэ хөрөнгө оруулалтын нөхцөл байдал үүсч ирэв. Энэ нь зөвхөн уул уурхайн салбарт хамааралтайгаас гадна мөн ложистикийн салбар зам тээвэр зэрэг олон салбарыг хөндөх юм. Нөгөө талаас их хэмжээний өрсөлдөөнийг ч дагуулах нь ойлгомжтой. Энэ нь 2009 оны 11 дүгээр сарын дундуур болсон “Discovery Mongolia” хэмээх геологичууд уурхайн салбарын олон улсын чуулганд оролцсон дотоод гадаадын компаниудын оролцоо, тэдгээрийн өөрсдийгөө танилцуулж байсан байдлаас ажиглагдаж байв. Монгол Улс нь Оюу толгой, Тавантолгойн хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын хөгжлийн шинэ эрин үетэй холбож байгаа бөгөөд энэ нь манай улс түүхий эдийн хавсарга орон болохоос урьдчилан сэргийлж түүхий эдээ өөрөө боловсруулах бодлого хэрэгжүүлэх чиглэлтэй байгаа билээ. Нөгөөтэйгүүр манай улс уул уурхайн болон мал аж ахуйн түүхий эдийн нөөцөө Хятадад шууд гаргаж байгаа асуудал хурцаар тавигдахын зэрэгцээ эх орондоо түүхий эдийг боловсруулах үйлдвэржүүлэлтийн бүтээн байгуулалтыг шийдвэрлэх чухал асуудал эрчимтэй яригдаж хэрэгжүүлэх шатанд ороод байна. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтэд нийт экспортод түүхий эдийн эзлэх хувийн жин 60%-иас хэтэрвэл гадаад орны түүхий эдийн нийлүүлэгч хавсарга жинтэй эдийн засгийн бүтцийг бий болгодог² гэсэн заалтаас даваад байгаа юм.

Иймээс дээрхи хоёр ордыг ашиглахдаа Сайншандад түүхий эдийн тээвэрлэлт, боловсруулах бүхэл бүтэн цогцолбор байгуулах төсөл яригдаж байна. Манай улс түүхий эдээ өөрөө боловсруулах нь бусад орны түүхий эдийн хавсарга улс болохоос зайлах таатай нөхцөл яг энэ цаг үед тулгараад байна. 2009 оны сүүлчээр УИХ-ын дарга Д.Дэмбэрэлийн санаачилгаар зэсийн баяжуулах үйлдвэр барих асуудлаар их хурлын дэргэд тусгай комисс байгуулсан нь манай улс үйлдвэржилтийн шинэ шатанд гарах нөхцөл бололцоог судалж байгаагийн нэг том жишээ юм. Бид энэхүү төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхдээ хөрш зэргэлдээ хоёр хөршийн туршлага мөн хөрөнгө оруулалтанд түшиглэх нь мэдээж хэрэг. Тухайлбал: ОХУ нь сүүлийн үед инновацийн бодлогын талаар түлхүү ярих болсон бөгөөд ОХУ-ын ерөнхийлөгч А.Медведев XXI зуунд Орос гүрэн нь түүхий эдийн хавсарга улс хэвээр байгаа нь байж болшгүй зүйл гээд инновацийн /шинэчлэлийн/ бодлогын хэрэгжилтээс Орос орны цаашдын хувь заяа шууд шийдэгдэнэ гэж хэлсэн нь манай улсын хувьд нэг төрлийн дохио болсон гэж хэлж болно. Үүнийг ч хөрш зэргэлдээ Орос улсын бизнесменүүд шууд манайд анхааруулан хэлж байгаа явдал мөн, тухайлбал Оросын төмөр замын агентлагийн дарга Якунин саяхан манай сурвалжлагчидад өгсөн ярилцлагадаа: “Монгол Улс нь ОХУ-ын гашуун туршлагыг давтахгүй байж болох талаар ярьсан”.

Монгол Улс бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг хил орчмын хамтын ажиллагаатай уялдуулан авч үзэхийг эрхэмлэж байгаа билээ. Монголын эдийн засгийг бүхэлд нь Дорнод хэсгээр дамжуулан Зүүн болон Зүүн хойт Азийн орнуудтай хоршин хөгжүүлэх гол чиглэл болгох баруун бүсээр дамжин Хятад, Орос, Казахстан, Европын холбооны улс, Төв Ази, Дундад Ази, Ойрхи Дорнодын орнуудын худалдаа, эдийн засгийн сүлжээнд холбогдох, Хангайн болон Төвийн бүсийг Орос, Хятадын зах зээлийн багтаамжинд түшиглэн Ази, Европыг холбосон хөгжлийн коридор /хонгил/ зэрэг бүс нутгийг дэлхийн глобал эдийн засагт нэгдэн нийлүүлэх уялдуулан зохицуулах чиглэлээр ажиллах. Зүүн хойт Азийн орнуудын хүрээнд Монголын Зүүн бүсийн Чойбалсан, Сүмбэр, Нөмрөгийн чиглэлээр Номхон далайн бүс нутгийн орнуудтай холбох тээврийн коридор нээх боломжийг судлах асуудлууд тавигдсаар байна. Дээрхи төслүүд нь манай хөрш БНХАУ-тай салшгүй холбоотой. Иймээс бид БНХАУ-ыг манай орны хөгжлийн чухал хүчин зүйлийн нэг мөн хэмээн зүй ёсоор үздэг. Чингэхдээ бид тодорхой үр дүнд хүрэх Хятадын хөрөнгө оруулалтыг хүсч байгаа, чухамхүү ийм л арга замаар эдийн засгийн хамтын ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна. Өнөөдөр эдийн засгийн хамтын ажиллагааны үндэс суурь тавигдаж тодорхой үе шатанд хүрсэн.

БНХАУ нь Монголд оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулалттай компаний бүртгэгдсэн тоогоороо тэргүүлж, гол төлөв геологи, уул уурхайн судалгаа хайгуул, олборлолт, худалдаа, нийтийн хоол, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт хийж байна. БНХАУ-ын хувьд байгалийн баялаг, ашигт малтмалын түүхий эд ган төмөр, зэс, эрчим хүч, газрын тосны хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр нөөц дутагдалтай байгаа нь хоёр орон бие биеэ нөхөн хөгжих сайхан боломжийг нээж байгаа юм. 2007 оны байдлаар Хятад нь манай улсын уул уурхайн салбарын 60%-д хөрөнгө оруулалт хийжээ.³ Гэвч сүүлийн жилүүдэд Монгол Улсад оруулж буй гадаадын хөрөнгө оруулалтын нийт хөрөнгийн 60% нь уул уурхайн олборлох салбарт орж ирсэн нь хөрөнгө оруулалтын бүтэц хэт өрөөсгөл байгааг харуулж байгаа юм.

БНХАУ нь Монгол Улсад хөрөнгө оруулалтаараа тэргүүлж байгаа боловч хөрөнгө оруулалтын бодит нөхцөл байдалд зайлшгүй шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлууд оршсоор байна. Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн харилцаа, хөрөнгө оруулалтын тухайд оршиж буй дутагдал, нөхцөл байдлын талаар хоёр улсын холбогдох байгууллагуудын хэмжээнд авч хэлэлцдэг боловч өдий хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Манай улсын ашигт малтмалын талаархи хууль тогтоомжийн цоорхойгоос үүдэн гарсан ашигт малтмалыг эрж хайх, олборлох, ашиглах эрхийг шууд ба шууд бусаар эзэмших, хөрөнгө оруулагч гадаад дотоодын компаниудын үйл ажиллагаа, түүнд зуучлагч нарын ашиг сонирхлоос болж элдэв зөрчил, хүндрэл гарсаар байна. Ялангуяа уул уурхай, ашигт малтмалыг Хятадын жижиг компаниуд, хувь хүмүүс хууль бусаар олборлох явдал ихэссэнтэй холбоотойгоор түүнд ашиглагддаг цианит натри, мөнгөн ус, метилийн спирт гэх зэрэг химийн бодисыг хилийн боомт газруудаар нууцаар нэвтрүүлэн оруулж, хаа сайгүй ашиглаж, нутаг орон, ард иргэдийг хордуулах болов. Зөвхөн хоёр жишээ дурьдахад, Дархан-Уул аймгийн Хонгор сумын ард иргэд хууль бусаар алт угааж байсан хятад иргэдийн цианит, мөнгөн усанд хордож, үр дагавар нь өдгөө хүртэл үргэлжилсээр байна. Мөн Тавантолгойн нүүрсний уурхайгаас хүнд даацын ачааны тэргээр Хятад руу олон жилийн турш нүүрс тээвэрлэснээс онгон байгалийн хөрсийг эвдэж, дур зоргоороо салаалсан олон зам гаргаж, тоосоор дарж, нөхөн сэргээлт хийгээгүйн улмаас өргөн уудам нутагт мал аж ахуй, хөдөө аж ахуй эрхлэх ямар ч боломжгүй болгожээ. Ийнхүү Монголын олон аймаг, сум, орон нутгийн уул ус, бэлчээр, тариалан уурхайн олборлолтонд өртөж, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдах, гол горхи ширгэж, цөлжилтийн аюул нүүрлэн, цэвэр усны нөөц хомсдох боллоо. Монголд ашигт малтмал олборлож буй Хятадын

тал зам харгуй гаргаж, бэлчээр нутгийг сүйтгэн, нөхөн сэргээлт хийхгүй гарч байгаа билээ. Гэвч үүнийг эдгээр компаниуд нь Хятадын албан ёсны хөрөнгө оруулалтын зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд биш, хууль бусаар орж ирсэн жижиг компаниуд гэж хятадын тал тайлбарладаг.

Стратегийн ач холбогдол бүхий байгалийн баялаг, үйлдвэрлэлийг ашиглахтай холбогдуулан гадаадын хөрөнгө оруулагчдад улс орны үндэсний аюулгүй байдалтай холбоотой тодорхой нөхцлүүдийг дагаж мөрдөх шаардлага тавьдаг. Тухайлбал: Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэг орноос авах стратегийн ач холбогдолтой түүхий эд, тоног төхөөрөмж, мэргэжилтэн, ажилчдын тоо хэмжээг үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхөөргүй байх хэмжээнд байлгахыг заасан байдаг. Гэвч эдгээр заалт бодит амьдрал дээр хэрэгжихгүй, манай улсад ажиллаж буй гадаадын ажилчид түүн дотор хятадын ажилчид тухайн орны хууль тогтоомжийг үл тоомсорлон, дүрэм журмыг дагаж мөрдөх явдал туйлын хангалтгүй байсаар ирлээ.

2006 оны байдлаар Монгол Улсад Хятадын хөрөнгө оруулалттай 2177 пүүс компани бүртгүүлж,⁴ эдийн засаг худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гэх боловч хоёр орны Засгийн газрын зөвшөөрөлтэй ирж ажиллаж буй нь харьцангуй цөөн, дийлэнхи нь хууль бусаар ажиллаж байгаагаас элдэв зөрчил, бэрхшээлтэй тулгарч, олон сөрөг үр дагавар гарсаар байна. Монголд ажиллаж буй Хятадын зарим компани, жижиг аж ахуйн нэгжүүд, үйлдвэрүүд Монгол Улсын хууль дүрэмд захирагддаггүй, татвараас зайлсхийдэг, монгол хүний нэрээр ажиллах эрхийн бичиг гэрээ, лиценз авдаг, монгол ажилчдынхаа цалинг тогтмол төлдөггүй, хөдөлмөр хамгааллын дүрэм журам зөрчдөг, ариун цэврийн наад захын шаардлага хангадаггүй гэх мэт үйлдэлүүд их гаргадаг. Энэ бүхэн нэг талаас манай улсад ажиллаж буй хятадын хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалтыг дагалдан орж ирсэн ажилчдын хариуцлагагүй байдал, нөгөө талаас хятад ажилчдыг хууль бусаар оруулж байгаа монголын талын зарим компани, хувь хүмүүстэй шууд холбоотой.

Монгол Улсын хөгжлийн хандлагаас гадаадын ажиллах хүч авах хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байна. Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 1994 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах журам”, 2001 онд УИХ-аар баталсан “Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль” дүрэм журмын дагуу зохицуулж байна.

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар бол цагаачид манай хүн амын нэг хувиас хэтрэх ёсгүй байдаг.

Түүн дотроо нэг улсын иргэн дээрхи нэг хувийн 0,33 хувиас ихгүй байхаар хуульчилжээ. Манай улс жил бүр 25 мянган хятад ажилчид авдаг⁵ гэсэн тооцоо байгаа боловч холбогдох тоо баримтууд хоорондоо маш зөрүүтэй байна. Зөвшөөрөлтэй ирж буй хятад иргэдийн олонхи нь барилга, уул уурхайн салбарт ажилладаг. Хууль бусаар зөвшөөрөлгүй ирж байгаа хятад ажилчдын ихэнхи нь бичиг үсэггүй, ажлын чадваргүй, эрүүл мэндээр сул дорой, хөдөөний тариачид ажлын хямд хөлсөөр орж ирж байна. Тэдгээр нь Улаанбаатар хотоос гадна хөдөө орон нутагт зөвшөөрөлгүй суурьшиж, байгаль экологитой зохисгүй харьцаж, ховор ан амьтан, шувуу, загасыг олноор нь зүй бусаар агнаж, хилийн боомтуудаар хууль бусаар гаргах оролдлого хийхээс гадна элдвийн гэмт хэрэгт холбогдож байна. Иймээс манай улсын холбогдох байгууллагууд шалгалт хийж тэдгээр иргэдийг саатуулан нутаг буцаах үйл ажиллагаа тогтмол явуулж буйг дурьдах хэрэгтэй болов уу. Тухайлбал: 2009 оны 10 дугаар сарын байдлаар 2365 хятад иргэдийг албадан нутаг буцаажээ.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хөрөнгө оруулалт, худалдааны хамгийн том түнш бол БНХАУ бөгөөд экспортод тэргүүлж, импортын хэмжээгээр удаах байрыг эзэлж байна. Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу албан ёсоор хөрөнгө оруулалт хийхээс гадна томоохон пүүс компаниуд, жижиг аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрууд, хувь хүмүүс бие даан янз бүрийн салбарт хөрөнгө оруулалт хийж байна. Мөн түүнчлэн монголчууд, хятадуудтай худалдаа арилжаа хийж, хамтарсан үйл ажиллагаа явуулж, тоног төхөөрөмж, барилгын материал, ахуйн хэрэгцээний эд барааг оруулж ирэхээс гадна жимс ногоо, гурил будаа гэх мэт хүнсний хэрэгцээг оруулж ирдэг. Тэдгээр хувиараа оруулж ирж буй эд бараа, ялангуяа хүнсний бүтээгдэхүүн нь чанарын шаардлага хангаагүй, баталгаа, шинжилгээгүй байдаг. Гэтэл манай улсын эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан шалгуур үзүүлэлтэд хүнсний хэрэглээнд импортоор авч буй хувь 30%-иас хэтрэхгүй байхаар заасан⁶ боловч бид хүнсний барааныхаа бараг 50%-ийг урд хөршөөсөө оруулж байна.

Монгол Улсаас албан ёсоор зөвшөөрөл авсан хятадын хөрөнгө оруулалттай худалдаа, нийтийн хоол, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зарим хамтарсан жижиг аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтын хэмжээ, техник технологи, тоног төхөөрөмж нь чанарын шаардлага хангахгүй, гарсан бүтээгдэхүүн нь хэрэгцээ шаардлагад нийцэхгүй явдал их байгааг хэлэх хэрэгтэй. Иймэрхүү байдал нь хоёр орны харилцаанд сэв суулгах, дүрэм журмаар нь үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн газрууд, компаний нэр хүндэд сөргөөр нөлөөлөх талтай. Иймд нэгдүгээрт, Монгол Улс хөрөнгө оруулалтынхаа орчинг оновчтой бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын хууль

тогтоомжийг улам боловсронгуй болгох шаардлагатай байна. Хоёрдугаарт, хоёр улсын засгийн газрын хооронд албан ёсоор байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулагчдын аюулгүй байдлыг хангах, нэр хүнд, эрх ашгийг хамгаалах талаар хууль, дүрэм, журмаа сайтар цэгцлэх хэрэгтэй. Гуравдугаарт, манай улсад оруулж буй гадаадын хөрөнгө оруулалт, ялангуяа хятадын хөрөнгө оруулалтыг аль болох үлдэгтэй, үр өгөөжтэй, байгаль экологид ээлтэй, дэд бүтэц, зам харилцаа, ус, эрчим хүч гэх мэт томоохон бүтээн байгуулалтанд оруулах шаардлагатай байна. Үүний тулд хоёр тал сайтар судалгаа явуулж, орчин үеийн шинжлэх ухааны үндэслэлтэй, өндөр техник, технологийг нэвтрүүлсэн ихээхэн хөрөнгө оруулалттай, үлгэр жишээ, оновчтой томоохон бүтээн байгуулалт хийх хэрэгтэй байна.

Ийнхүү Хятадын хөрөнгө оруулалтын өгөөж, үр дүнг тойрсон асуудал тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Цаашид хоёр орны эдийн засгийн харилцааг чанарын шинэ шатанд гаргахын тулд нэн тэргүүнд хоёр орны эрх ашигт нийцүүлсэн, харилцан бие биенээ нөхсөний үндсэн дээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх нь зохистой. Манай улс өөрийн хөгжлийн зорилтын үүднээс ямар салбарт аль орны хөрөнгө оруулалт хийх нь илүү оновчтойг судлан гаргах шаардлагатай болж, энэ чиглэлээр зарим нэгэн судалгаа, санал ажлын түвшинд байгааг хэлэх хэрэгтэй.

Юуны түрүүнд бид үйлдвэрлэл голлосон экспорт-үйлдвэрлэлийн эдийн засгийн бүс байгуулах нь илүү оновчтой гэж үзэж байна. Манай хоёр тал мөн хамтран эдийн засгийн чөлөөт бүсийн ямар хэлбэр илүү тохиромжтойг судлаж болох мэт. БНХАУ нь чөлөөт бүс байгуулах арвин туршлагатай орон, далайд гарцгүй нутагт тухайлбал ӨМӨЗО-ны Хөх хотын дөрвөн талд эдийн засгийн чөлөөт бүс байгуулсан туршлагатай бөгөөд энэ нь далайн эрэг хавийн бүс нутгийн чөлөөт бүсээс онцлог юм. Иймээс хоёр орон Эрээн, Замын-Үүдийн чөлөөт бүсийг тус бүрдээ байгуулж худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг түргэсгэх зорилт тавьсан боловч хүссэн үр дүнд хүрээгүй болно. Учир нь Эрээн хотод хэдийгээр дэд бүтэц байгуулж эхэлсэн боловч усны нөөцийн асуудал хүндрэлтэй болж Эрээнийг зөвхөн бараа хадгалах, бараа тээвэрлэх хэмжээнд ашиглах болж байгаа талаар Хятадын эрдэмтэд дурьдаж байсан. Замын-Үүдийн хувьд чөлөөт бүс зөвхөн эхлэлийн хэмжээнд байгаа бөгөөд усны асуудал энэ нутагт бас маш хүндрэлтэй байна. Иймээс хоёр тал аль болохоор чөлөөт бүс байгуулахын тулд юуны өмнө усны нөөцийн судалгааг тус тусдаа буюу хамтран төсөл байгуулж хэрэгжүүлэх нь маш чухал тулгамдсан асуудлын нэг болоод байна. Ийнхүү чөлөөт бүс байгуулахад маш нарийн судалгаа хэрэгтэй бөгөөд “Экспортын бүс байгуулах дэлхийн

ассоциаци” зэрэг байгууллагууд энэ чиглэлээр ажилладаг байна. Манай улсын гол зорилго бол экспорт-үйлдвэрлэлийн чиглэлийн бүс байгуулах явдал юм.

Хил орчмын болон хил дамнасан хамтын ажиллагааны хувьд гэвэл манай талын боомтуудын нөхцөл байдал, тэдгээрийн эдийн засгийн ач холбогдлын асуудал чухал юм. Манай улс олон жил өмнөд хилийн боомтуудын нөхцөл байдлыг сайжруулах тэдгээрийн түргэн шуурхай ажиллагаа болон жилийн дөрвөн улиралд тогтмол ажиллуулах зэрэг асуудлыг хөндсөөр ирсэн болно. Гэвч энэ асуудал одоо хир шийдвэрлэгдээгүй хэвээр байгаа, үүнийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх асуудал тавигдсан боловч энэ нь хараахан шийдвэрлэгдээгүй байна. Юуны өмнө Ярант, Бургастай, Гашуунсухайт, Шивээ-Хүрэн, Бичигт, Хавирга, Ханг, Даян зэрэг боомтуудын талаар яригдаж байгаа бөгөөд энд тэмдэглэхэд манай улсын хувьд эдгээр боомтуудын эдийн засгийн ач холбогдлыг нарийн тооцоолон гаргах шаардлага чухал болж, боомтуудыг дараа нь хэрхэн ашиглах, дэд бүтцийг бий болгох, терминал аж ахуй, ложистикийн төв байгуулах зэрэг асуудал шийдвэрлэгдэх болно. Энэ чиглэлийн хөрөнгө оруулалт болон зээлийг Хятадын талтай хамтран шийдвэрлэх сонирхол манай талд бий.

Томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын хувьд гэвэл хэдийгээр Хятад улс гадаадын хөрөнгө оруулалтаар тэргүүн байр эзэлж байгаа боловч яг барьцтай, манай улсын хөгжлийн стратегид жинтэй хувь нэмэр оруулсан нь бас чамлалттай байгааг манай эдийн засагчид тэмдэглэхийн зэрэгцээ Монгол Улс нь Хятадын зах зээлд буюу Хятадын гадаад эдийн засагт өөрийн байр суурийг хараахан олж авч чадахгүй байгаа асуудал ч хөндөгдөж байна. Өнөөгийн байдлаар Монголд Хятадын аар саархан жижиг хөрөнгө оруулалт хангалттай байгаа бөгөөд тэдгээр нь хэдийгээр тооны хувьд их боловч чухамдаа шинэ технологи, инноваци-г /шинэчлэлийг/ авчрахгүй буюу удаашралтай байгаа тал ажиглагдаж байна. Нөгөөтэйгүүр үндэсний жижиг хөрөнгө оруулагчдын орон зайг эзэлсэн зэрэг нь үндэсний бизнесийн хөгжлийг боймлож байгаа тухай шүүмжлэл их бий. Манай улс зөвхөн уул уурхайн салбарт түшиглэхгүй мөн олон улсын тээвэр, эрчим хүч, аялал жуулчлал, мэдээлэл холбооны сүлжээнд хамрагдах бодлогыг баримталж байна. Нэн тэргүүнд шинэ технологи, тухайлбал нано-технологийг сонирхож байгаа болно. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хөгжилд үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалтыг дэмжих байр суурь зонхилж байна. Тухайлбал: нүүрсний том том уурхайнуудыг түшиглэн эрчим хүчний цогцолбор барих, Хятадтай газрын тосны салбарт хамтран ажиллах мөн түүнчлэн Монгол, Хятадыг холбосон газрын тосны коолой барих санал ч байгааг дурдсуй.

Манай улсын эдийн засгийн тулгамдсан асуудлын нэг бол юуны түрүүнд чанарын асуудал болж, улмаар олон улсын стандартыг

эрхэмлэх явдал газар авч байгаа бөгөөд ялангуяа барилгын салбарт манай орны газрын хөрс, цаг агаарт нийцсэн стандартыг бий болгох, эрчим хүчний хэмнэлт шинэчлэлийг дагуулсан байх нь чухал байна. Энэ чиглэлээр БНХАУ мөн ажиллаж тодорхой амжилтанд хүрч байгааг бид мэднэ. Тухайлбал: Гуанжоугийн эрчим хүчний хэмнэлттэй барилга юм. Бидэнд хөгжилтэй орнуудын “өчигдөрийн” технологийг өнөөдөр дууриаж давтахгүй, харин хөл зэрэгцэн алхаж хоцрогдлоосоо ангижрах шаардлага юу юунаас илүү тавигдаж байна. Үүнд мэдээжийн хэрэг их хэмжээний хөрөнгө мөнгө шаардагдахыг ч ойлгож байна. Иймээс манай тал Хятадын хөрөнгө оруулалттай олон улсын орчин үеийн стандартад нийцсэн Хятадын том барилгын компанитай хамтран ажиллаж орон сууцны хороолол барих, барилгын чанарын лаборатори зэргийг байгуулах сонирхол байна.

Манай улсын хөгжлийн чухал гарц бол зам тээвэр бөгөөд энэ салбарт технологийн горим алдагдах, хуучин технологи ашиглаж байгаа, орон нутгийн хөрс, цаг уурын онцлог, эрс тэрс уур амьсгал зэргийг харгалзаж үздэггүй гэх зэрэг дутагдлууд оршсоор байгаа нь манай хатуу хучилттай замын чанар муу, түргэн эвдэрдэг, эдийн засгийн хувьд маш хохиролтой байдаг. Иймээс манай тал хуучин технологиос салж цаг хугацааны хувьд түргэн, чанарын хувьд олон улсын стандартад нийцсэн технологи оруулж ирэх шаардлагатай байна. БНХАУ зам тавих өндөр технологи мөрдөж байгаа орон учраас манай улсад бүсийн хэмжээний авто зам байгуулахад Хятадын талын оролцоог бий болгох сонирхол их байна. Мөн Улаанбаатар–Замын-Үүдийн чиглэлд авто зам барих төсөлд Хятадын талыг оролцуулах. Үүнтэй холбоотой БНХАУ-аас зам барилга, уул уурхайн салбарт нарийн мэргэжлийн ажилчин авах асуудлыг зохицуулах хэлэлцээр хийх төлөвлөгөөтэй байгаа болно. Ер нь манай улсад Хятадаас өндөр зэрэглэлийн, нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтнууд, багш нарыг урьж, тэдгээрийг дагалдуулан нарийн мэргэжлийн ажиллах хүчийг бэлтгэж сургах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Энэ чиглэлээр мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн чиглэлийн сургуулиудыг ч хамтран байгуулж болох талтай.

Хятадын томоохон хөрөнгө оруулалтыг зөвхөн уул уурхайн салбарт бус мөн бусад салбарт өргөнөөр ашиглах боломж бий. Хөдөө аж ахуйн салбар нь хоёр орны хамтын ажиллагааны томоохон талбар, шинэ боломж гэж үзэж болно. Тухайлбал: мал аж ахуй. Манай улсын малын тоо толгой хангалттай өсч 50 саяд хүрэв. Чанар болон олон улсын стандартад нийцүүлэн эрүүлжүүлж махыг нь экспортлох явдал өнөөгийн мал аж ахуйн салбарын тэргүүн зэргийн зорилт болоод байна. Тэр тусмаа манай хоёр орны мал сүрэг, байгаль экологийн нэг бүсэд хамрагдах ба угаас бэлчээрийн шинж чанартай, мал маллах арвин туршлагатай. Гэвч

бэлчээрийн даац хэтэрсэн цөлжилт явагдаж байгаа өнөөгийн нөхцөлд шийдвэрлэх зохистой тулгамдсан асуудлууд гарсаар байгаа билээ. Энэ салбарт хоёр тал харилцан бие биеэсээ туршлага судлах, дутагдлыг давтахгүй байх, бие биеэ нөхөх боломж байгаа юм. Манай улс энэ чиглэлээр олон улсын хэмжээнд хамтран ажиллах сонирхолтой. Тухайлбал: 2009 оны сүүлчээр манай ерөнхий сайд асан С.Баяр Япон улсад айлчлах үеэр манай орны малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг тус улстай хамтран хэрэгжүүлж олон улсын стандартанд нийцүүлэх, экспортод гаргах монгол махны үнийг өсгөх зэрэг асуудлыг дэвшүүлсэн болно. Манай улс махны бүтээгдэхүүнийг хятадын зах зээл болон Хятад улсаар дамжуулан гуравдагч орны зах зээлд гаргах сонирхолтой байна. Нөгөөтэйгүүр эрчимжсэн мал аж ахуй, усжуулалт, хөдөө аж ахуйн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад Хятад улстай хамтран ажиллах нь илүү оновчтой хэмээн үзэж байна. Мөн хил дамнасан малын халдварт өвчинтэй тэмцэхдээ Хятад улстай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Манай улсын эрчимтэй хөгжлийн чухал түлхүүрийн нэг бол зам харилцаа. Иймээс Монгол Улс олон чиглэлээр төмөр зам байгуулах мөн авто замын сүлжээ барих төлөвлөгөөтэй байгаа. Тухайлбал: Улаанбаатар-Замын-Үүдийн чиглэлийн төмөр замын хоёрдахь шугам байгуулах, Говийн болон Зүүн бүсэд авто замын буюу төмөр замын сүлжээ байгуулах, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам барьж дуусгахад Хятад улсаас хөрөнгийн зээл тусламж авах зэрэг төлөвлөгөөтэй байна. Говийн бүсэд төмөр замын сүлжээ байгуулах ажил эхлээд байгаа. Энэ нь Монголын “MCS” компани Ухаа-Худгаас-Гашуунсухайт руу нарийн царигтай төмөр зам байгуулах ажлыг нэгэнт эхлүүлээд байна. Энэ нь Монгол-Хятадын хамтын ажиллагаа эрчимжих том суурь тавигдаж байгаа гэсэн үг юм. Энэ тухай улс төр судлаач М.Батцэцэг “...өнөөгийн тулгамдсан шаардлага, бодит боломж, нөхцөл байдал, зах зээлийн гол зарчим, эдийн засгийн үр ашиг зэргийг хэмжүүр болговол бид уул уурхайн хоёр гол орд Оюу толгой, Тавантолгойгоос гарах бүтээгдэхүүнээ хамгийн потенциал бүхий худалдан авагч, газар зүйн хувьд хамгийн ойр зэргэлдээ Хятад улс руу эхэлж экспортлох тухай бодох нь илүү үндэслэлтэй байх. ...Хятадын аварга том зах зээлд найдаагүй бол газар зүйн хувьд түгжигдмэл Монгол Улсыг хичнээн хөрөнгө оруулагчид яаран зорих байсан бол. Энэ үүднээс хоёр том ордоос газар зүйн хувьд хамгийн дөт өмнөд хилийн Гашуунсухайтын боомт руу төмөр зам тавих асуудал уг хоёр ордыг ашиглах эхлэлтэй адил ач холбогдолтой ...”⁷ гэжээ. Гэвч Монголын олон нийтийн дунд энэ талаар янз бүрийн үзэл бодол байгаагийн зохилох нь Монголын түүхий эд тухайлбал Оюу толгой, Таван толгойгоос түүхий эдийг боловсруулахгүйгээр шууд Хятад руу зөөх зам нээгдэж байгаа хэмээн үзэж байгааг дурдах нь зүйтэй болов уу.

Монгол Улс эрчимтэй хөгжлийнхөө замд орох тусам худалдаа, эдийн засгийн шинэ шинэ арга зам, аргачлалыг хайж байгаа бөгөөд тэдгээрээс дурьдваас Тяньжин, Жинжоу далайн боомтод тодорхой талбай, объект түрээслэх замаар гадаад худалдааны урсгалыг түргэтгэх, түүхий эдийн барааны /commodity trading/ бирж байгуулах зэрэг юм. Манай улс далайд гарцгүй орон учир хөрш зэргэлдээ орнуудын далайн боомтыг ашиглах сонирхолтой байдаг, 2009 оны 12 дугаар сүүлчээр ОХУ-ын Находка, Владивостокийн боомтыг ашиглахаар болж, улмаар манай улс хамгийн хямд төсөр тээвэрлэлт болох далайн тээвэрлэлтийг ашиглах бололцоо гарч байна.

БНХАУ-ын тусламж хөнгөлөлтэй зээл нь манай улсын шилжилтийн үед эдийн засгийн чухал хөшүүрэг болсныг тэмдэглэхийн хамт тэрхүү зээл тусламжийн өгөөж үр дүнг сайжруулах шаардлага байгааг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь зөвхөн Хятад улсын зээл тусламжид хамааралтай бус мөн бусад орны болон олон улсын байгууллагын хүрээнд олгосон зээлтэй холбоотойгоор манай нийгэмд яригдаж байгаа асуудал юм. Тухайлан яриваас зээлдүүлж буй тал зээл олгохдоо түүнийгээ ямар салбарт ашиглахыг шууд тулгадаг нь манай орны ашиг сонирхолд тэр бүр нийцдэггүй. Тухайлбал: ОХУ нь манай улсын хөдөө аж ахуйд зээл олгохдоо заавал өөрийн газар тариалангийн техникээ тулгаж өгсөн нь техникийн үзүүлэлтээрээ илүү бусад орны техник авах болоцоог хаасан юм. Чингэхдээ ОХУ-аас гурил будаа импортлож байгаа нь зээл авсан тариаланчдын орлогыг хааж, тэдний зээлээ төлөх нөхцлийг бүрдүүлж өгөхгүй байгаа зэрэг юм. Нөгөөтэйгүүр Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг олон улсын банк санхүүгийн байгууллагууд зээл тусламжийн бодлогоо тухай улс орны дотоод бодит нөхцөл байдал бүрдсэн бүрдээгүйг үл харгалзан зах зээлээ чөлөөл, ийм тийм арга хэмжээ ав хэмээн болзол тавьдаг явдал бий. Хөгжиж байгаа орны туршлагаас харахад дээрхи зөвлөмжийг үг дуугүй хэрэгжүүлсэн орны эдийн засаг нийгмийн амьдрал доройтож, өөрийн үзэл бодлоо хамгаалан тэмцсэн нь хөгжлийн замд орж чадсан байх. Энэ талаар эдийн засгийн ухааны Нобелийн шагналт Жозе Стиглиц олонтаа тэмдэглэсэн байдаг.⁸ Иймээс манай улс өөрийн хөгжлийн онцлог боломжоо харгалзан үзэж зээлийн зөв бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм. Цаашид бид өөрийн хөрш БНХАУ-аас зээл авах, мөн БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг ашиглах, Хятадын экспорт, импортын даатгалын “Синошур” компанийн 100 сая ам.долларын зээлийн бүрэн ашиглах асуудал дээр зээлийн үр дүн өгөөжийн асуудлыг сайтар бодолцох шаардлагатай байна.

Саяхан Монгол Улсын ерөнхий сайд С.Батболдын урилгаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Вэнь Зябао 2010 оны 6

дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Уг айлчлал БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын 16 жилийн дараа Монгол Улсад хийж буй албан ёсны айлчлал болж байгаагаараа онцлог байсан бөгөөд хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэх, харилцан итгэлцэл, ойлголцлыг нэмэгдүүлэх, Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны нэн ялангуяа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулж, ач холбогдолтой болсон юм. Айлчлалын үеэр хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал чухал байр суурь эзэлж, хоёр орны хоорондын худалдааг нэмэгдүүлэх, уул уурхай, санхүү, дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар тохиролцлоо. Тухайлбал, манай улсад уул уурхай, хөдөө аж ахуйн түүхийн эдийг гүн боловсруулж Хятадын болон гуравдагч орны зах зээлд нийлүүлэх, транзит тээврийн асуудалд, далайд гарах боомт гарцыг нэмэгдүүлэх зэрэг гол гол асуудлыг манай талаас тавьсан бөгөөд Хятадын тал дэмжлэг үзүүлэхээ илэрхийлжээ. Айлчлалын үеэр Хятадын талаас 50 сая юаний буцалтгүй тусламжийг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд зориулан олгох, батлан хамгаалах салбарт 10 сая юанийн тусламж үзүүлэхээр боллоо. Хятадын ерөнхий сайд Вэнь Зябао уул уурхайн томоохон төслүүдэд хятадын аж ахуйн нэгжүүдийг оролцуулах сонирхолтой байгаагаа илэрхийлэхийн сацуу боловсруулах аж үйлдвэр, түүний дотор хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар 500 сая ам.долларын хөнгөлттэй зээлийн шугамыг нээхээ мэдэгдсэн болно. Мөн айлчлалын үеэр зохиогдсон Монгол, Хятадын бизнес эрхлэгчдийн чуулга уулзалтанд Монгол Улсын ерөнхий сайд С.Батболд “БНХАУ-ын тууштай хүчин чармайлт нь эдийн засгийн хямралыг богино хугацаанд даван туулахад бүс нутаг, дэлхий нийтийн түвшинд чухал үүрэг гүйцэтгэж, хувьсан өөрчлөгдөж буй даяарчлагдсан дэлхийн эдийн засагт Хятад улс улам бүр чухал байр суурийн нэгийг эзэлж байгааг цохон тэмдэглээд, Хятад улс өнгөрсөн хугацаанд дэлхийн нийтийн аж үйлдвэрийн нэг чухал төв нь болж чадсан бол одоо дэлхийн урт хугацааны өсөлтийн нэг эх үүсвэр болох зах зээл нь болж байгааг дурьдав. Иймд энэ улстай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь манай хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм”⁹ гэв. Ийнхүү манай улс хөгжлийнхөө шинэ шатанд гарч буй өнөө үед гадаадын оновчтой хөрөнгө оруулалт юу юунаас чухал байгаа, энэ утгаараа хоёр орны эдийн засаг хамтын ажиллагаа харилцан ашигтай, урьд урьдынхаасаа илүү үр дүнтэй хөгжих боломжтой болж байна. ХКН-ын ХҮИ их хурлаар хөрш орнуудтайгаа найрамдал, түншлэлийн харилцааны бодлогоо үргэлжлүүлж, сайн хөршийн

харилцаа, бодит хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх тухай, мөн бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэхдээ аюулгүй, тогтвортой орчныг хамтран байгуулахын төлөө, бололцооныхоо хэрээр хөгжиж буй орнуудад тусламж дэмжлэг үзүүлж, хөгжиж буй орнуудын нийтлэг эрх ашиг, хууль зүйн шаардлагыг хангахын төлөө ажиллана гэж заасан. Иймд манай улс БНХАУ-ын эдийн засгийн хурдацтай хөгжлийн туршлага дээр дөрөөлөн, хоёр улс бие биеэ харилцан нөхөх боломжийг бүрэн ашиглаж, улс орноо цэцэглүүлэн хөгжүүлэх хэрэгтэй байна. Үүний тулд манай хоёр орон хоорондын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж, харилцан ашигтай, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтынхаа үр дүнг нээлттэй, ил тод болгон, хөрөнгө оруулалтдаа хяналт, шалгалт хийж, учирч буй саад бэрхшээл, үл ойлголцолыг даван туулж, өнгөрсөн үйл явц, туршлагаас сургамж авч, хамтын хүчин чармайлтаар даван туулах хэрэгтэй байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Б.Ганзориг, Д.Начин Монгол улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин – “Олон улс судлал” сэтгүүл, 2007 №1, т.30
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. “Дорно-Өрнө” сэтгүүл. 1994, №2 т.14
3. “Олон Улс Судлал” сэтгүүлийн 2009, №2 т. 24
4. “Өнөөдөр” сонин. 2007.05.7
5. “Өнөөдөр” сонин. 2007.05.12, №113/3071/
6. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. “Дорно-Өрнө” сэтгүүл. 1994, №2, т.14
7. М.Батцэцэг В.Путиний айлчлал геополитикийн том нүүдэл мөн үү? “Өдрийн сонин”, №111, 2008.05.08
8. Ж.Стиглиц. Дэлхийчлэл ба түүний сэтгэлд үл нийцэх нь” УБ. 2007
9. <http://www.mfat.gov.mn>